Д.Мө 1
110

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ-д

2026 оны 08 сарын 03

Хяналтын гомдол гаргах нь:

Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 07 сарын 06-ны өдрийн 210\МА2026\01534 дугаартай "Магадлал"-ыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6, 167 дугаар зүйлийн 167.5,172 дугаар зүйлийн 172.1 дэх хэсэгт зааснаар хяналтын гомдол гаргаж байна.

Нэхэмжлэгч О.Амарзаяагийн хариуцагч П.Машбатад холбогдуулан "гэрлэлт цуцлуулж, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох, дундын эд хөрөнгөөс ногдох хувь гаргуулах" шаардлага бүхий нэхэмжлэлтэй иргэний хэргийг анхан болон давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1, 126 дугаар зүйлийн 126.2 дахь хэсэг, 129, 130 дугаар зүйлийн 130.3, буруу тайлбарлаж, Гэр бүлийн тухай хууль болон Иргэний бүртгэлийн тухай хууль, УДШүүхийн 2017 оны 12 сарын.25-ны өдрийн 03 зөвлөмжөөс өөрөөр хэрэглэлэсэн нь хяналтын гомдол гаргах хууль зүйн үндэслэл болж байна

Давж заалдах шатны шүүх нэхэмжлэгч О.Амарзаяагийн "Гэрлэлт цуцлуулж, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох, дундын эд хөрөнгөөс ногдох хувь гаргуулах" шаардлага бүхий нэхэмжлэлтэй П.Машбатад холбогдох иргэний хэргийг хянан шийдвэрлэхдээ хариуцагчийн гаргасан давж заалдах гомдолд хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт өгч чадаагүй, нэхэмжлэлийн зарим шаардлага, нэхэмжлэгчийн тайлбараас ангид байдлаар хууль бус дүгнэлт өгч шийдвэрлэсэн.

Нэхэмжлэгч О.Амарзаяа нь П.Машбатад холбогдуулан "Гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгож, дундын эд хөрөнгөөс ногдох хувиа гаргуулах" шаардлага гаргасан.

Харин нэхэмжлэгч нь "...хүүхдээ өөрийн асрамжинд авна, тухайн байр ашиглалтанд ороогүй учраас орон сууц захиалгын гэрээний дагуу урьдчилгаанд өгсөн төлбөрөөс өөрт болон хүүхдэд ногдох хэсгээс мөнгөн хэлбэрээр гаргуулах, тээврийн хэрэгсэлээс ногдох хэсгээс гаргуулах, болж өгвөл байрнаас авч байгаа мөнгөө багасгаад ч болов машинаа авмаар байна" гэх тайлбарыг шүүх хуралдаанд гаргасан байдаг

Анхан шатны шүүх дээрх нэхэмжлэлийн шаардлага, тайлбарт дурьдсан "хүүхдийн амьдрах тав тухтай орчиныг тогтоох, дундын эд хөрөнгө байгаа эсэх, тухайн байр өмчлөлд шилжсэн эсэх, захиалсан байрны нийт үнэ, үүнээс үлдэгдэл төлбөр байгаа эсэхийг шүүх баримтаар тогтоох ажиллагаа хийгээгүй, нэхэмжлэгчийн тайлбар нь бусад бичгийн баримтаар нотлогдоогүй, эдгээр асуудалтай холбоотой шинээр нотлох баримт зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүсч байхад ИХШХШТХуулийн 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсэгт зааснаар "шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах ..."хуулийн заалтыг хэргжүүлээгүйгээс хариуцагч П.Машбат гэр оронгүй, хүүхэдгүй, ямар ч хөрөнгөгүй, өр төлбөртэй үлдэж, шүүх ямар нотлох баримтыг шийдвэрийн үндэслэл болгосон нь ойлгомжгүй байдлаар хэргийг шийдвэрлэсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчилсөнөөс дараах хууль бус үр дагавар үүссэн гэж үзэж байна.

Анхан шатны шүүх хариуцагчийг нэхэмжлэлийн шаардлагыг маргаагүй гэж дүгнэсэн байхад давж заалдах шатны шүүх маргасан гэж 2 өөр байдлаар дүгнэсэн.

Нэхэмжлэгч хариуцагч нар гэр бүлийн хамтын амьдралтай байх хугацаандаа 2021 оны 09 сарын 29-ний өдөр "Бүрэн констракшн" ХХК-тай "Орон сууцны барилгын ажлыг захиалгаар гүйцэтгэх" гэрээг байгуулж, Хан-Уул дүүрэг 11 хороо "Лакшири Зайсан Виллаж" хотхон 101 блокын 7 давхарын В тоот 61,51 м\кв талбайтай 3 өрөө орон сууцыг 141 473 000 төгрөгөөр худалдан авахаар тохиролцоод урьдчилгаа 85 хувь буюу 120 559 600 төгрөгийг төлж 15 хувь буюу 20 913 400 төгрөгийг төлөгдөөгүй хамтран хариуцах өр болон үлдсэн байхад аль ч шатны шүүх эрх зүйн дүгнэлт өгөөгүй.

"Магадлал"-д: Талуудын хоорондын маргааны зүйл болсон 56-69 УКУ улсын дугаартай Toyota Camry-XY50 маркийн автомашин, орон сууц захиалгын гэрээний дагуу төлсөн 120 599 600 төгрөгийг анхан шатны шүүх гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө болохыг тогтоож, гэр бүлийн гишүүдэд ногдох хэсгийг гаргуулж шийдвэрлэсэн нь Иргэний хуулийн 130 дугаар зүйлийн 130.3 дахь хэсэгт нийцсэн байна" гэж дүгнэжээ.

Гэтэл тухайн орон сууц нь гэр бүлийн хамтран өмчлөх үл хөдлөх эд хөрөнгө болж бүртгэлийн байгууллагад бүртгэгдэж гэрчилгээ олгогдоогүй, гэрээ байгуулсан компанийн өмч мөн эсэх нь эргэлзээтэй бөгөөд тус барилгын үйл ажиллагаа 2 жил таг зогссон, барилга баригдаагүй хариуцагч хохирсоныг нэхэмжлэгч сайн мэднэ.

Давж заалдах шатны шүүхийн дээрх дүгнэлт нь "нэхэмжлэгчийн шаардаагүй, анхан шатны шүүхийн шийдвэрлээгүй асуудлаар буюу "...захиалгын гэрээний дагуу төлсөн 120 599 600 төгрөгийг анхан шатны шүүх гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө болохыг тогтоосон" мэтээр үндэслэлгүй дүгнэлт хийсэн нь ИХШХШТХуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсэг, УДШүүхийн 2017 оны 12 сарын.25-ны өдрийн 03 дугаар зөвлөмжийн 5-д:" Гэрлэлтээ цуцлуулж буй гэрлэгчдийн эд хөрөнгийн маргаанд тэдгээрийн бусдад төлөх төлбөр өрийн асуудал тавигддаг. Өр нь эд хөрөнгийн эрх зүйн үр дагавартай тул хуваагдах хөрөнгөнд хамаарна, өр нь аливаа бусад хөрөнгийн адил гэрлэгчдийн хооронд тэнцүү хуваагдана" заалттай нийцээгүй ба гэрлэлтийн хугацаанд бий болсон орон сууцны үлдэгдэл 20 913 400 төгрөгийн төлбөр нь гэр бүлийн гишүүдийн дундын үүрэг гэж үзэж байна.

"Магадлал"-д: анхан шатны шүүх гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн үнийн дүнг 52 519 866 төгрөг гэж тодорхойлсон, 37 000 000 төгрөгийн үнэлгээтэй тээврийн хэрэгсэлийг нэхэмжлэгч О.Амарзаяагийн өмчлөлд шилжүүлэхийг хариуцагч П.Машбатад даалгаж, хариуцагч П.Машбатаас мөнгөн хэлбэрээр 15 519 866 төгрөг, хүү М.Чингүнд ногдох хэсэг болох 52 519 86 төгрөг нийт 68 390 732 төгрөгийг хариуцагч П.Машбатаас гаргуулж нэхэмжлэгч О.Амарзаяад олгож шийдвэрлэсэн нь зөв болжээ" гэж дүгнэхдээ УДШүүхийн 2017 оны 12 сарын.25-ны өдрийн "Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал" 03 зөвлөмжид заасан "Хүүхэд гэрлэлтээ цуцлуулж буй эцэг эхийнхээ хөрөнгийг адил тэнцүү хуваах авах эрхгүй бөгөөд шүүх тухайн маргааныг хянан шийдвэрлэхэд хүүхдийн эрх ашгийг харгалзан үзэх л үүрэгтэй болохоос бус гэрлэгчдийн эд хөрөнгийг хүүхдүүдэд нь тэнцүү хуваадаг нь эрх зүйн хувьд алдаатай болно" гэх заалт, Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1,125 дугаар зүйлийн 125.1, 126 дугаар зүйлийн 126.2.2, 129 дүгээр зүйлийн 129.3 дахь заалтуудыг тухайн хэрэг маргаанд оновчтой зөв тайлбарлан хэрэглээгүй, УДШүүхийн 2009 оны 20 дугаар тогтоол, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль", "Гэр бүлийн тухай хууль"-ийн зэрэг хэрэглэх

ёстой хуулийг хэрэглээгүйгээс шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан байна.

Давж заалдах шатны шүүх ИХШХШТХуулийн 118 дугаар зүйлийн 118.4-д: “Үндэслэх” хэсэгт: “хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг шүүхээс хэрхэн үнэлж байгаа тухай заана”, УДШүүхийн 2006 оны 4 сарын 25-ны өдрийн “Зөвлөмж”-ийн 4.2-д: “үндэслэх хэсэгт шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримтыг заахаас гадна үндэслэл болох боломжгүй байгаа баримтуудыг дурьдаж, тэдгээрийг хэрхэн үнэлсэн талаар тусгах” хуулийн болон зөвлөмжийн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд ИХШХШТХуулийн 176 дугаар зүйлийн 176.2.5 -д зааснаар Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2026 оны 03 сарын 11-ний өдрийн 192\ШШ2026\02772 дугаартай “Шийдвэр”, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 07 сарын 06-ны өдрийн 210\МА2026\01534 дугаартай “Магадлал”-ыг хүчингүй болгож өгнө үү.

\Хяналтын шатны шүүх хуралдаанд хариуцагч, өмгөөлөгч нар оролцох хүсэлттэй байна\.

Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт 8 хуудас хавсаргав

Гомдол гаргасан:
Хариуцагч.....П.Машбат
Утас:91331100
Өмгөөлөгч Л.Жавзмаа
Утас: 99030984